

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ж.ЭРДЭНЭБАТ ТАНАА

Танилцуулга хүргүүлэх тухай

Цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээний үр дүнд иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг тодорхойлох зорилгоор 2014 онд 4 удаа 789 иргэнээс 11 асуулт бүхий санлын хуудсаар авч нэгтгэхэд цагдаагийн хэлтсийн үйл ажиллагаанд санал асуулгад оролцсон иргэдийн 80 хувь нь цагдаагийн байгууллагаас шаардлагатай тусламжыг бүрэн үзүүлж чаддаг, амьдарч байгаа орчноо аюулгүй байдалд байдаг, мөн цагдаагийн байгууллагаас явуулж байгаа үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байгаа талаар хариулсан байна.

2014 оны 04 дүгээр сарын 22 ны өдөр 201 иргэнээс “Олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийн хүрээнд “Аюулгүй амар тайван орчин” бүрдүүлэх зорилгоор, 2014 оны 06 дугаар сарын 10 ны өдөр иргэд олон нийт цагдаагийн байгууллагатай хамтарч ажилдаг эсэх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодруулах зорилгоор 200 иргэнээс, 2014 оны 08 дугаар сарын 23 ны өдөр Цагдаагийн хэлтсийн ажил үйлчилгээний үр дүнд иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг тодорхойлох зорилгоор 320 иргэнээс тус тус санал авч Хууль зүйн яам түүний харъяа агентлаг, байгууллагуудын “Нээлттэй хаалга”-ны өдрийг 2014 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр Чингэсийн талбайд явуулах болсонтой холбогдуулан Нийслэлийн цагдаагийн газрын хэмжээнд “Иргэнээ сонсоё” уриан дор зохион явуулах өдөрлөгийг угтсан “Эрх чөлөөтэй монгол хүн” зорилтын хүрээнд иргэдээс санал авах ажлыг 2014 оны 09 дүгээр сарын 11 ний өдрийн 17-19 цагийн хооронд дүүргийн 6 дугаар хорооны 68 иргэнийг хамруулан тус хорооны хурлын заалан цагдаагийн хэлтсийн дарга цагдаагийн хурандаа Г.Эрхэмбаяр, Нийслэлийн цагдаагийн газрын НХЖХГ-н ХЖХ-н тасгийн дарга цагдаагийн дэд хурандаа Л.Амармөрөн, цагдаагийн хэлтсийн хэсгийн байцаагч хариуцсан ахлах байцаагч цагдаагийн ахмад Б.Гүнчин-иш, хорооны хэсгийн байцаагч цагдаагийн ахмад Л.Мишигбаатар, олон нийтийн цагдаагийн ажилтан Т.Цэцэгсүрэн, хорооны засаг дарга Ц.Дунгармаа нарын бүрэлдэхүүнтэй уулзалт ярилцлага зохион байгуулан иргэдээс гаргасан санал хүсэлтийг хүлээн авч асуусан асуултанд холбогдох хүмүүс хариулж хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй ажил, түүний үр дүнг иргэдэд таниулан сурталчилж ажиллаа.

Иргэдээс санал авах арга хэмжээнд оршин суух хороодын иргэдийн дунд нэр хүнтэй олны танил бэлтгэл хошууч генерал Р.Гүнчин-иш, урлагийн гавъяат зүтгэлтэн Б.Дугарсүрэн, ахмад дайчин Ч.Адъяа нарын хүмүүс оролцсон нь уг уулзалт санал авах ажлыг ач холбогдолтой болгож иргэдээс оролцох оролцоог сайн болгосон.

Арга хэмжээнд оролцсон иргэдээс 7 иргэн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг дэмждэг талаараа сэтгэгдэлээ илэрхийлж 4 иргэн орон сууцны байранд нохойтой иргэд, мөн “Бөө” хүмүүс амьдарч амгалан тайван байдал алдагдуулж байгаа талаар мөн СӨХ-үүд иргэдийг аюулгүй амар тайван орчинд амьдруулах талаар ажил хийхгүй хангалтгүй ажилладаг орон сууцны байруудыг

камертай болгох талаар санаачилга гаргахгүй байгаа тул цагдаагийн байгууллагаас энэ тал дээр анхаарч төр захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай байна гэсэн саналууд гарсныг хүлээн авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

ДАРГА Д.ГАНБОЛД